

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ

2007 оны 7 дугаар сарын 27-ны өдөр

Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ 2007 оны 7 дугаар сарын 27-ны өдөр	1.1.Энэ хуулийн зорилт нь төрөөс жижиг, дунд үйлдвэрийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож, тэдгээрийг дэмжих талаар авах арга хэмжээ, хамрах хүрээг тодорхойлон үндэсний эдийн засгийн хөгжлийг хангахад оршино.	5 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч 5.1.2.контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 149-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий бөөний худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн; 5.1.3.контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 199-өөс дээшгүй бөгөөд 1.5 тэрбум төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэн; 5.1.5.контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 19-өөс дээшгүй бөгөөд үйлдвэрлэл эрхэлдэг, эсхүл контракт, хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын тоо нь 9-өөс дээшгүй бөгөөд худалдаа, үйлчилгээ эрхэлдэг, 50-250 сая төгрөг хүртэлх жилийн борлуулалтын орлого бүхий жижиг үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн 11 дүгээр зүйл. Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх 11.1.5.жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах; 11.1.6.жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим, төрийн бус бусад байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох; 14.2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч дараахь үүрэг хүлээнэ: 14.2.3.зохих стандарт, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ эрхлэх; 17 дугаар зүйл. Жижиг, дунд үйлдвэрийн менежментийн үндэс суурийг бэхжүүлэх 17.3.Аж үйлдвэрийн болон худалдааны төвлөрлийг бий болгох талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ: 17.3.2.аймаг, нийслэл, сум, дүүргийн хот төлөвлөлтийн дагуу жижиглэнгийн худалдаа болон үйлчилгээ эрхлэгчдэд зориулан худалдаа, үйлчилгээний төв, гудамж байгуулах, тухайн нутаг дэвсгэрт оршин суудаг иргэд болон үйлчлүүлэгчдийн эрх, ашиг сонирхолд нийцсэн барилга байгууламж, дэлгүүр барихад дэмжлэг үзүүлэх. 18 дугаар зүйл. Эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд зохицох чадварыг нэмэгдүүлэх, эрсдэлээс хамгаалах 18.1.Жижиг, дунд үйлдвэрийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд зохицох чадварыг нэмэгдүүлэх талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ: 18.1.1. Худалдааны бүтэц, түүхий эдийн нийлүүлэлтэд гарсан өөрчлөлт нь жижиг, дунд үйлдвэрийн үйл ажиллагаанд саад учруулсан буюу учруулж болзошгүй тохиолдолд бизнесийн тогтвортой байдлыг хангах, өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлэх;